

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг чуулганы 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Хуулийн төсөл санаачлагчийн үзэл баримтлалыг зарчмын хувьд дэмжиж, дараах нэмэлт, өөрчлөлтүүдийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ашигт малтмалын тухай хуульд орууллаа Үүнд:

Үндэсний геологийн албаны чиг үүргийг хуульд шинээр тодорхойлж, Засгийн газрын бүрэн эрхэд Үндэсний геологийн албыг байгуулах, стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагийг тогтоох, хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгох талбайг солбицлоор тогтоож мэдээлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбоотой дэд бүтэц хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай байгуулах гэрээний загварыг батлах, ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээнд авах зорилгоор төрийн мэдэлд шилжүүлж авах, нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохирсоны үндсэн дээр энэ хуулийн 19.12, 26.9-д заасан талбайгаас тусгай зөвшөөрөл олгох асуудлыг нэмж тусгалаа.

Төр, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоод, иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Бодлогын зөвлөл байгуулж бүрэлдэхүүн ажиллах журмыг батлах, уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журам, баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага түүний үйл ажиллагаа эрхлэх журам, эрдэс баялагийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам, салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам, төрийн бус байгууллагатай хамтран ашигт малтмалын баялаг, ордын нөөц хайгуулын ажлын үр дүнг нийтэд нээлттэй тайлагнах зэрэг журмуудыг батлах асуудлыг Геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хамааруулахаар боллоо.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэгт өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа ажил үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгохдоо тэргүүн ээлжинд Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжид давуу эрх олгохоор, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэнэтийн осол саатал, шүүхийн шийдвэр, улсын байцаагчийн акт болон бусад давагдашгүй шалтгаанаар уурхайн бүтээн байгуулалт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоохдоо геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлэх, олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдхүүнээ Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа боловсруулах үйлдвэрт зах зээлийн үнээр нийлүүлэх, өөрийн хаяг, утас, факсны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд 14 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх,

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүрэгт орд ашиглах техник эдийн

засгийн үндэслэлдээ бүтээгдэхүүн тээвэрлэх дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн сэргээлт болон хаалтад шаардагдах хөрөнгийн талаар тусгах, байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалтын асуудал хариуцсан ажилтантай байх,

Тусгай зөвшөөрлийн төлбөртэй холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараа жилийн төлбөрөө хуульд заасан хугацаанд урьдчилан төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд тухайн жилд төлөх төлбөрийн үнийн дүнгийн 0.3 хувиар тооцон 30 хоног хүртэл алданги ногдуулна. Энэ хугацаанаас хэтэрвэл ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахаар хуулинд өөрчлөлт оруулан хуульчлан баталгаажууллаа.

“Ашигт малтмалын баялаг”, “ашигт малтмалын ордын нөөц”, “мэргэшсэн мэргэжилтэн шинжээч” гэсэн нэр томъёог хуульд шинээр нэмж, “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд”, “бичил уурхай эрхлэх” гэсэн нэр томъёог өөрчлөн найруулсан болно.

Түүнчлэн байгалийн өнгөт болон үнэт чулууг түүж, олборлохдоо ердийн ашигт малтмалын адил тусгай зөвшөөрөл авах, нэг тусгай зөвшөөрлөөр олгох хайгуулын талбайн хэмжээг 150 мянган гектараас ихгүй байхаар, хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг гурван жилээр 3 удаа сунгаж, тусгай зөвшөөрлийн төлбөрийг хайгуулын талбайн гектар тутамд 10-12 дахь жилд 5 америк доллар, хайгуулын ажлын зардлын доод хэмжээ, түүнийг баталгаажуулахад тусгай зөвшөөрлийн 10-12 дахь жилд 10 америк доллар байхаар, хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг 3 удаа сунгасантай холбоотой хуулийн “ашиглалтын өмнөх үйл ажиллагаа” гэсэн зүйлийг хүчингүй болгосон. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргах мэдээ тайлангийн хугацаанд өөрчлөлт оруулж, хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтан, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгасан болно.

Энэ хууль батлагдсанаар 2012 оны 01 сарын 12-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийг хүчингүй болгож, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулж, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль шинээр баталсан. Хуулиар тухайн үед мөрдөгдөж байсан хуулийн дагуу байгуулсан ашиглалтын өмнөх гэрээг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын хугацаанд шинэчлэн бүртгэхээр тусгасан.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдснаар Монгол улсын геологи уул уурхайн салбарын бүтээмж, өрсөлдөх чадвар нэмэгдэж хөрөнгө оруулалт ихээр шаарддаг энэ салбарын улс орны эдийн засаг нийгмийн хөгжилд оруулах хувь нэмэр өсөж цаашид эдийн засгийн тогтвортой өсөлт хадгалагдах боломж бүрдэнэ.

Танилцуулга бичсэн:

Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн зөвлөх

Б.Мөнхцэцэг Утас:264405, 99094802

